

НЭГ. 2015 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар

1. Уулын ажлын зорилтын биелэлт

2015 онд 6650,0 мян.м³ хөрс хуулан 900,0 мян.тн нүүрс олборлон борлуулах зорилт тавин ажилласан бөгөөд энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд уулын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд жилд дундажаар 430 ажиллагсад /үүнээс 104 эмэгтэй, 326 эрэгтэй/ оролцсон байна. Үүнээс 161 хүн өдрийн 8 цагийн, 259 хүн хоногийн 12 цагийн 2 ээлжтэйгээр ажиллаж хөрс хуулалт, нүүрс олборлолтын үйл ажиллагааг хийж гүйцэтгэлээ.

Уулын ажлын төлөвлөгөөт үзүүлэлтийн гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Нэгж	2014 он	2015 он		2014 онтой харьцуулсан үзүүлэлт
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нүүрс олборлолт	м.тн	749.7	900.0	758.5	+8.8
2	Нүүрс борлуулалт	м.тн	707.3	900.0	758.4	+51,1
3	Хөрс хуулалт	м.м3	7729.9	6650.0	4570.0	-3159,9
	Тээвэртэй	м.м3	6949.4	5970.0	3796.5	-3152,9
	Тээвэргүй	м.м3	780.5	680.0	773.5	-7,0
4	Уулын цул	м.м3	8306.5	7342.3	5153.5	-3153.0
5	Шидэлт	м.м3	404.2	180.0	202.8	-201,4
6	Өрөмдлөг	м.у.м	47.2	46.0	56.4	+9,2
7	Тэсрэх материал	м.тн	382,8	500.0	455,5	+72,7
8	Тэсэлсэн уулын цул	м.м3	1214,2	2676.0	1143,1	-71,1
9	Х.Х.Кoeffициент	м3/тн	10.31	7.39	6.03	


2015 онд уулын ажлын хувьд гол хийсэн ажил нь 2015-2016 оны өвлийн оргил ачааллын үед олборлох 350,0 мян.тн нүүрсний нөөцийг нээж бэлтгэн оны эцэст 150,0 мян.тн нүүрсний нөөцтэй шилжсэн болон 2016-2017 оны өвөл олборлох нүүрсний нөөц нээх хөрс хуулалтын ажлыг төлөвлөсөн талбайнуудад хийж гүйцэтгэсэн явдал юм.

2015 онд нүүрс олборлолтын төлөвлөгөө тасалдсан гадаад хүчин зүйл бол манай голлох хэрэглэгчдийн санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой төлбөрийн хүндрэл, тэдгээрийн үйлдвэрлэлийн зогсолт саатал, нүүрс худалдан авалтаа багасгасан зэрэг болно.

Харин хөрс хуулалтын төлөвлөгөө тасалдахад Норд Бенз, Doosan төрлийн машинууд болон голлох цахилгаан экскаваторуудын эвдрэл саатлаас шалтгаалсан сул зогсолт их гарсан нь голлон нөлөөлсөн.

Тэсэлгээний үйл ажиллагаа явуулж байгаа гэрээт компанийн ажлын зохион байгуулалттай холбоотойгоор тэсэлгээний хугацаа алдсан, өрөмдлөг тэсэлгээний ажлын чанарын хяналт зохицуулалт хангалтгүй зэргээс шалтгаалан хөрс хуулалтын ажилд хүндрэл гарч байв.

2014 оноос ялгагдах гол үйл явдал нь Нүүрс угаан баяжуулах үйлдвэр ашиглалтанд оруулсан, уулын ажлын дотоод зохион байгуулалт болон нүүрсний чанарын хяналтыг сайжруулсан, улны болон туслах блок талбайнуудын ус шүүрүүлэлтийг сайн хийж нүүрс олборлолт явуулсан зэрэг болно.



Хойд блок	
төл. 520.0 м.м ³	гүй. 1058.5 м.м ³
төл. 100.0 м.тн	гүй. 209.6 м.тн
5.20	5.05

Хойд блокийн гарш	
төл. 1500.0 м.м ³	гүй. 693.6 м.м ³
төл. 300.0 м.тн	гүй. 41.9 м.тн
5.00	16.55

Төв блокийн хойд ул	
төл. 0 м.м ³	гүй. 169.7 м.м ³
төл. 0 м.тн	гүй. 47.9 м.тн
0	3.54

Төв блокийн урд хэсэг	
төл. 2160.0 м.м ³	гүй. 2337.3 м.м ³
төл. 390,0 м.тн	гүй. 374.4 м.тн
5,54	6,24

Өмнөд блок	
төл. 750.0 м.м ³	гүй. 311.0 м.м ³
төл. 110.0 м.тн	гүй. 84.5 м.тн
6.82	3.68

Уулын ажлын төлөвлөгөөт үзүүлэлтийн гүйцэтгэлийг талбайн байрлал блок тус бүрээр үзүүлэв.

Нийт нүүрс олборлолтын 49.5 хувь нь Төв блокоос, 27.5 хувь нь Хойд блокоос, 11,9 хувь нь Өмнөд блокоос, 4,9 хувь нь Хойд блокийн гаршаас, 6,2 хувь нь Төв блокийн хойд улны хэсгээс тус тус хийгдсэн байна. Дээрхи блокуудын нүүрсний давхаргын тогтоц, чанарын үзүүлэлт шаардлага хангахгүй байсан учраас ус шүүрүүлэлтийн ажлыг тасралтгүй зохион байгуулснаар Төв блокийн урд болон хойд ул хэсгийн талбайнуудаас улны нүүрс олборлох ажлыг амжилттай зохион байгуулсан.

Уул техникийн нөхцөлийн хувьд Өмнөд блокийн хөрсний гулсалт, нүүрсний блокуудын усны ундрага, чулууны үеүүд, овоолгын орон зайн хязгаарлалт зэрэг онцлог хүндрэлтэй нөхцөлд уулын ажлын өрнөлтийг явууллаа.



2. Техникийн ашиглалт засвар үйлчилгээний талаар

2015 онд уулын ажлын зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд доор үзүүлсэн техник тоног төхөөрөмжүүдийг ашиглан ажиллаа. Үүнд:




ЭКГ-8И экскаватор - 1 ш. Ашиглалт 27 жил

ЭКГ-5А экскаватор - 2 ш. Ашиглалт 26-39 жил

ЭКГ-4У экскаватор - 2 ш. Ашиглалт 27 жил



DA-40 автосамосвал /45 тн/ - 3ш. Ашиглалт 2 жил




DI550 Сандвик өрмийн машин -1 ш. Ашиглалт 2 жил



ТЭМ-2 илчит тэрэг - 1 ш. Ашиглалт 9 жил



Коматцу- 155А бульдозер -1 ш. Ашиглалт 9 жил



SHANTU бульдозер 1 ш. Ашиглалт 5 жил



ЭШ-10/70 алхагч экскаватор - 1 ш Ашиглалт 37 жил



HD465-7R автосамосвал /60 тн/ - 7 ш. Ашиглалт 2 жил



Норд Бенз автосамосвал /30тн/ - 3 ш. Ашиглалт 3 жил



CAT-16G автогрейдер - 1 ш. Ашиглалт 22 жил



GD-655 автогрейдер - 1 ш. Ашиглалт 1 жил

DX-500 гидроэкскаватор - 1 ш. Ашиглалт 1 жил

DX-520 гидроэкскаватор - 1 ш. Ашиглалт 2 жил

DX-700 гидроэкскаватор - 1 ш. Ашиглалт 2 жил



SD-200 дугуйт ачигч - 1 ш. Ашиглалт 1 жил

SD-300 дугуйт ачигч - 1 ш. Ашиглалт 2 жил

Техникийн ашиглалтын хувь үзүүлэлт

№	Тоног төхөөрөмж нэр	Календар цаг	Төлөвлөгөөт засвар цаг	Ажиллавал зохих цаг	Сул зогсолт		Ажиллавал зохих цаг	Бүтээлтэй ажилласан цаг	Бэлэн байдлын коэффициент	Техник ашиглалтын коэффициент
					Техникийн эвдрэл	Бусад				
1	НордБенз машин	16026	2528	13498	1853	2867	11645	8778	86.3	65.0
2	HD-465 машин	64104	10112	53992	4373	5970	49619	43649	91.9	80.8
3	DA-40 машин	24039	3792	20247	3521	7385	16726	9341	82.6	46.1
4	DX гидро экс.	24039	3792	20247	1491	1360	18756	17396	92.6	85.9
5	SD дугуйт ачигч	10927	1723	9204	528	738	8676	7938	94.3	86.2
6	ЭШ-10/70 экс.	8013	1264	6749	609	30	6140	6110	91.0	90.5
7	ЭКГ экскаватор	32052	5056	26996	3231	1422	23765	22343	88.0	82.8
8	Бульдозер	16026	2528	13498	7157	668	6341	5673	47.0	42.0
9	Илчит тэрэг	8760	1314	7446	0	0	7446	7446	100.0	100.0
10	Грейдер	8013	1264	6749	0	450	6749	6299	100.0	93.3
11	Усны машин	2914	459	2455	11	160	2444	2284	99.6	93.0
12	Өрөм	8760	1380	7380	815	671	6565	5894	89.0	79.9
13	Дамжлага	8760	725	8035	128	4	7907	7903	98.4	98.4

2015 онд техникийн засвар үйлчилгээний нэгжийн ажлын зохион байгуулалтыг сайжруулан үйл ажиллагааг хэвшүүлж эхэлсэн нь гол амжилт байлаа.

Олон улсын жишгээр уул уурхайн салбарт техникийн ашиглалтын хувь хэмжээ 80-85-аас багагүй байвал хэвийн буюу боломжын ашиглалттай гэж тооцдог бөгөөд манай компанийн хэмжээнд 2015 оны техник ашиглалтын дундаж хувь 80,3 байна.

Зарим төрлийн техникийн ашиглалтын хувь хангалтгүй байгаад нөлөөлсөн гол хүчин зүйл бол тэдгээрийн элэгдэл болон ашиглалттай холбоотой эвдрэл гэмтэл, түүнийг засварлахад шаардагдсан сэлбэг материалын олдоц ховор байгаагаас хугацаа алдсан болон хэрэглэгчдээс нүүрсний төлбөр төлөлт удаашралтай байгаатай холбоотой сэлбэг хүлээгдсэн сул зогсолт зэрэг байна.

3. Борлуулалтын үйл ажиллагааны талаар

2015 онд бид 900,0 мян.тн нүүрс борлуулах зорилт тавин ажилласан бөгөөд борлуулалтыг нэмэгдүүлэх, нүүрсний чанарыг сайжруулах тал дээр дараахь арга хэмжээг авч ажиллаа.

- Томоохон хэрэглэгчидтэй шинээр гэрээ байгуулж борлуулалт нэмэгдүүлсэн.
- Чанарын хяналтыг сайжруулснаар илчлэгийн зөрүүгийн алдагдлыг бууруулсан
- Нүүрс шигших төхөөрөмжийг өөрсдийн нөөц бололцоог ашиглан хийж ашигласнаар хэрэглэгчдийн чанарын санал гомдол багассан
- Жижиглэнгийн борлуулалтын төслийг Улаанбаатар, Дархан хотуудад хэрэгжүүлсэнээр борлуулалтын хэмжээг нэмэгдүүлсэн.
- Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийг барьж ашиглалтанд оруулан туршилтын угаалтыг амжилттай хийж, эхний борлуулалтыг хийлээ.

Нүүрс борлуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг
голлох хэрэглэгчдээр үзүүлэв

№	Байгууллагын нэрс	Төлөвлөгөө / мян.тн /	Гүйцэтгэл /мян.тн/	Зөрүү
1	Дархан ДЦС	260.0	273.6	13.6
2	Эрдэнэт ДЦС	280.0	287.8	7.8
3	Эрдэнэт үйлдвэр	102.0	113.1	11.1
4	Силикат ХХК	3.6	1.8	-1.8
5	Сутайн үхэр чулуут ХХК	0.0	3.1	3.1
6	Хөтөл цементийн үйлдвэр	72.0	6.4	-65.6
7	Ачит ихт ХХК	0.0	6.2	6.2
8	Дархан төмөрлөгийн үйлдвэр	30.0	6.9	-23.1
9	Нако түлш ХХК	35.0	4.1	-30.9
10	Дулаан Шарын гол ТӨХК	15.4	11.7	-3.7
11	УБТЗ	12.5	0.0	-12.5
12	Жижиглэн	27.8	23.8	-4.0
13	Гэрээгүй иргэд	0.0	7.1	7.1
14	Эрэл цемент	40.78	0.0	-40.8
15	Бусад	20.96	12.8	-8.2
Нийт		900.0	758.4	-141.6

Хэдийгээр бид 2015 онд төлөвлөсөн хэмжээндээ хүрч борлуулалтыг хийж чадаагүй ч ДЦС-ууд болон Эрдэнэт үйлдвэрт нийлүүлэх нүүрсний хэмжээг давуулан биелүүлж ажиллажээ. Зарим томоохон хэрэглэгчдэд нийлүүлэх төлөвлөгөө хангагдаагүй байгаа нь тухайн хэрэглэгч тодорхой хугацаанд үйлдвэрлэл явуулаагүйтэй холбоотой юм.

Тухайлбал: Хөтөл цементийн үйлдвэр болон Дархан төмөрлөгийн үйлдвэрт хувьчлал явуулж байгаатай холбоотойгоор үйл ажиллагаагаа жилийн ихэнх хугацаанд зогсоосон. Эрэл цементийн үйлдвэр нь 2015 онд үйл ажиллагаа явуулаагүй.

Жижиглэнгийн борлуулалтын үйл ажиллагааны тухай

2014-2015 оны өвлийн улиралд Дархан хотод нүүрсийг шуудайлан жижиглэнгээр амжилттай борлуулсан. Үүнд үндэслэн 2015 онд Улаанбаатар болон Дархан хотод жижиглэн борлуулалтын үйл ажиллагааг төслийн хэмжээнд боловсруулан хэрэгжүүлж ажиллаа. Улаанбаатар хотын зөвхөн гэр хорооллын айл өрхийн өвлийн түлшний нийт хэрэглээг тооцвол 600,000 тонн гэсэн судалгаа байдаг.


Энэхүү төслийг хэрэгжүүлснээр 300-400 ажлын түр байрыг бий болгож 1,497.8 сая төгрөгний орлого олсон байна.



УБ хотод нүүрс бууж байгаа нь



Ачилт хийж байгаа нь



Шигшин ангилах тоног төхөөрөмж



Борлуулалтын цэг



Дархан хотын шуудайлж бэлтгэсэн нүүрс

4. Байгаль орчин хамгаалал, нөхөн сэргээлт

Байгаль орчны бодлого нь манай компанийн үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг бөгөөд олон улсын ISO 14001:2004 (Байгаль орчны удирдлагын тогтолцоо) стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд 2015 онд хийгдсэн гол ажлууд:

- Компанийн Байгаль орчны бодлогын бичиг баримтыг боловсруулан мөрдөж эхлүүлсэн.
- Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны 5 жилийн төсөл боловсруулан түүний дагуу жил бүрийн төлөвлөлтийг хийж байна.
- Байгаль орчны мониторингийн хүрээнд орчны төлөв байдлын шинжилгээг тогтмол хийж байна.




Галын голомт устгасан ажлын зураг



Галын голомт дарж унтраасны дараа

2015 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТАЙЛАН

№	Үзүүлэлтүүд		Гүйцэтгэл		Тайлбар
			га	м ³	
1.	Хэмжих нэгж		га	м ³	
2.	Уурхайн эдэлбэр газрын хэмжээ		1826.18	1.826.180	
3.	Уулын ажилд хамрагдах нийт талбай		-	-	
4.	Тухайн онд шинээр эвдрэлд өртсөн талбай		-	-	2015 онд эвдрэлд өртсөн газар байхгүй болно
5.	Нөхөн сэргээлт хийх талбай.		3.1		
5.1	Үүнээс:	Дүйцүүлэн хамгаалах ажил	1.0	-	Гар аргаар алт олборлогч иргэдийн ухаж эвдсэн газрыг түрж тэгшилсэн.
5.2		Шимт хөрсний нөхөн сэргээлт	3.1	6.2 м.м3	20-30 см зузаантай шимт хөрсөөр хучилт хийсэн.
5.3		Биологийн нөхөн сэргээлт			
6.	Нөхөн сэргээлтэнд төлөвлөсөн зардал			16.1сая.төг	
7.	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу хийх ажил	1. Агаар, ус, хөрсний шинжилгээ.		1.2 сая.төг	2 удаа ус агаар хөрсний шинжилгээ хийлгэсэн.
		2. Хатуу шингэн хог хаягдал цэвэрлэх		0.5 сая.төг	2 удаа хатуу хог хаягдал цэвэрлэсэн.
		3. Гүний ус, гуанз, эмнэлэг, усны шинжилгээ		1.0 сая төг	3-4 удаа усны шижилгээ хийлгэсэн.
		1. Усалгаа, тоос дарах арга хэмжээ		43.0сая.төг	Үйл ажиллагааны зардалд хамаарна.



Техникийн нөхөн сэргээлт хийж буй байдал

Уурхайн эдэлбэр талбайн орчим архелогын судалгаа хийлгэн түүхийн дурсгалт були хэргэсүүр 18 ш тогтоогдсон () ★

5. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн ажлын талаар

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаарх олон улсын OHSAS-18000 стандартыг бүрэн нэвтрүүлж хэрэгжүүлэх нь манай компанийн гол зорилтын нэг юм.

Энэ зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2015 онд дараах ажлуудыг хийсэн. Үүнд:


- Компанийн ХАБЭА-н удирдлагын тогтолцооны баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.
- Удирдлагын тогтолцоотой уялдан үйл ажиллагааны дотоод журмуудыг шинэчлэн боловсруулж байна.
- ХАБЭА-н хяналтын системийг сайжруулан үзлэг шалгалтыг тогтмолжууллаа.
- ХАБЭА-н сургалт сурталчилгааг эрчимжүүлсэн.
- ХАБЭА-н стандартын дагуу зохион байгуулалтыг нэгж тус бүр дээр идэвхжүүлснээр осол гэмтэл, зөрчил өмнөх оноос буурсан байна.

№	Хийж гүйцэтгэсэн ажлууд	2014 он	2015 он	Зардал, хамрах хүрээ
1	Аваар осол гарахаас урьдчилан сэргийлж хийсэн төлөвлөгөөт ажлууд	3	8	Компанийн хэмжээнд болон тодорхой нэгжүүдэд чиглэсэн
2	ХАБЭА-н сургалт	11	8	
3	Түр зааварчилга өгөлт	7	12	Ажлын шинэ байр ба түр ажиллагсад
4	Анхааруулга мэдэгдэл өгсөн байдал	27	52	Нийт ажилтанууд болон тодорхой нэгжүүдэд чиглэж өгөгдсөн.
5	Үзлэг шалгалтанд хамрагдсан байдал	2	4	Дархан-Уул аймгийн ОБГ, МХГ, Хөдөлмөрийн хэлтэс
6	Аюулыг илрүүлэх үзлэг шалгалт хийсэн	14	89	Нийт ажлын байр болон хэсэг нэгжүүдэд
7	Аюулгүй ажиллагааны хурал хийсэн	-	5	Хэсэг нэгжийн удирдлагуудын хүрээнд
8	Аюулгүй ажиллагааны сургалт - мэдээлэл	-	33	Нийт хэсэг нэгжүүдэд
9	Туршилт баталгаажуулалт хийлгэсэн	2	5	Өргөх механизм, хэмжүүрийн хэрэгсэл
10	Шинээр хийсэн самбар тэмдэгт, санамж	72	115	НБУ, ШТС, АХМХ, УАГ, зам талбай
11	Ажлын хувцас, хамгаалах хэрэгсэл олголт	144.4 сая.төг	162.1 сая.төг	Нийт ажиллагсад
12	Үйлдвэрлэлийн осол	6	3	Хангамж, НААХэсэг
13	Аюултай тохиолдол	35	24	Компанийн хэмжээнд
14	Архины зөрчил	30	20	



Осолдогчдод тусламж үзүүлэх сургалт

Тохиолдлын төрлүүд	2014	2015
Осолд дөхсөн тохиолдол	6	6
Эмчийн тусламж авсан гэмтэл	7	1
Хугацаа алдсан гэмтэл	8	7
Өөр ажилд шилжүүлсэн гэмтэл	0	0
Автын ослын тохиолдол	0	2
Галын тохиолдол	1	2
Өмчийн эвдрэлийн тохиолдол	11	6
Архины зөрчил	30	20



ХАБЭА-н нөхцөл байдал өмнөх онтой харьцуулахад сайжирсан, энэ чиглэлээр нэлээд идэвхтэй үйл ажиллагаа явуулсан, үр дүнтэй ажилласан гэж дүгнэж байна.

6. Хүний нөөц хөгжүүлэлт, нийгмийн хариуцлага, орон нутгийн харилцааны талаар

Хүний нөөцийн бодлого :

Компанийн хөгжил, техник технологийн дэвшилтэй уялдуулан, ажиллах хүчний хэтийн хэрэгцээг тодорхойлж шаардлагатай мэргэжлийн боловсон хүчнээр хангах, хүний нөөцийн урсгал хөдөлгөөнд дүн шинжилгээ хийн ажил үүргийн давхардалыг багасгах, ажилчдын ур чадвар мэргэжлийн төвшинг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах урамшуулалын арга хэмжээг зохион байгуулах бодлогыг баримтлан ажиллаж байна.

Компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй зарим бодлого, дүрэм журам:

- Хүний нөөцийн цалин хөлсний бодлого
- Сарын үр дүнгийн журам
- Цаг бүртгэлийн журам
- Ажлын байрны тодорхойлолт
- Ажлын байранд түр шилжин ажиллах тухай журам
- Захиран зарцуулах эрхийн бодлого
- Уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны бодлого
- Уулын үйлдвэрлэлийн өмнөх шатны бодлого
- Мөнгөн хөрөнгийн удирдлагын бодлого
- Үндсэн хөрөнгийн бодлого
- Худалдан авалтын бодлого
- Нүүрс худалдан борлуулах бодлого
- Ашиг сонирхлын зөрчилийн бодлого
- Системд хандах эрхийн бодлого

Сургалт зохион байгуулалт, хөгжүүлэлт:

2015 онд тодорхой чиглэлүүдээр 18 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 612 хүн хамрагдан 4,2 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт ажиллагсад Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/33 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Нийт ажилтны сургалтын үлгэрчилсэн хөтөлбөр”-ийн дагуу сургалтыг тогтмол зохион явуулж, шалгалт аван баримтжуулж байна.

- ХАБЭА-н сургалтанд ашиглах сургалтын материал, хичээлүүдийг шинэчилж, боловсронгуй болгон бэлтгэсэн.
- Зарим сургалтыг гадны байгууллагатай хамтран зохион байгуулж ажилтнуудаа сурган, мэргэжил дээшлүүлж байна.
- Мягмар, Пүрэв гаригуудад өглөөний шуурхай хурал дээр тогтмол явагддаг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хичээлүүдийг тогтмол явуулж хэлтэс, хэсэг, алба бүрийн удирдлага нийт ажиллагсадаа мэдээлэж хэвшсэн.
- Нийт ажиллагсдын хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Хөдөлмөрийн хууль, ХАБЭА-н хуулиар төрөл бүрийн уралдаан тэмцээнийг зохион байгуулсан.



ХХААБО-ны хэсгийн ажилтнуудын баг, ажлын байранд графикаар үзлэг шалгалт хийж зөвлөгөө өгч байдаг.

Нийгмийн хариуцлагын хүрээнд доорх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Шарын гол сумын ард иргэд нүүрсний үнийн хөнгөлөлт үзүүлсэн.

- Шарын гол суманд шинээр байгуулагдсан цэцэрлэгт хүүхдүүдийн урлагийн хөгжилд зориулан хөгжим хандивласан.
- Дархан-Уул аймгийн асрамжын “Энэрэл” төвд номын сангийн тохижуулалтанд 2,0 сая төгрөгийн тусламж үзүүлсэн.
- Дархан-Уул аймгийн амжиргааны доод төвшиний ахмадуудад нүүрсний буцалтгүй тусламж үзүүлсэн.
- Мэргэжлээс шалтгаалах өвчлөлтөөс шалтгаалсан нөхөн олговрын 10 хүний өргөдөл гомдолыг шийдвэрлэж 36.0 сая төгрөгийн тусламж, нөхөн олговрыг олгосон.
- Ажиллагсдын буцалтгүй тусламж хүссэн 24 хүний өргөдөл гомдолд 13.9 сая төгрөг.
- Ахмад уурхайчидаа Цагаан сараар хүлээн авч 18,3 гаруй сая төгрөгийн гарын бэлэг гардуулсан.

Орон нутгийн харилцаа:

- ✓ Орон нутгийн төр захиргаа, сумын ААНБайгууллагуудтай байнга хамтарч ажиллаж байгаа бөгөөд цас зуд, үер борооны гамшгийн хүндрэлийг арилгах, байгаль орчны цэвэрлэгээ хийх, урлаг соёл спортын олон нийтийн арга хэмжээнүүдийг амжилттай зохион байгуулж идэвхитэй оролцож ирсэн.
- ✓ Мөн сумын Цагдаагийн тасагтай хамтарч “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх” сургалт зохион байгуулсан байна.
- ✓ Онцгой байдлын ангитай хамтарч байгалийн гамшиг, онцгой байдалд техник тоног төхөөрөмж хүн хүчний бэлтгэл хангах талаар үзүүлэх сургалт зохион байгуулсан.



Онцгой байдлын ангитай хамтарсан үзүүлэх сургалтын үеэр

7. Дотоод хяналтын талаар

Монгол улсын Засгийн Газрын 2011 оны 311-р тогтоолоор баталсан Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмыг үндэслэн компанийн үйл ажиллагааны онцлогт тохируулан “Дотоод хяналт шалгалтын журам”-ыг боловсруулан хяналт шалгалтын жил улиралын ажлын төлөвлөгөөг Гүйцэтгэх захиралаар батлуулан ажиллаж байна.

Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг /дүрэм, журам, зааврууд гэх мэт/ цэгцлэх, шинэчлэн боловсруулахаар хэсэг нэгжийн дарга нараас санал авч нэгтгэн 59 журам зааврыг цэгцэлж шинэчлэн боловсрууллаа.

Аймгийн мэргэжлийн хяналтын хэлтэс болон цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 5 албан бичиг, шаардлагын дагуу зохих арга хэмжээ авч хариуг заасан хугацаанд нь өглөө.

ХХАлба, ГХХАлба болон хэсэг нэгжийн удирдлагуудтай хамтран дотоод хяналт шалгалтыг 6 чиглэлээр давхардсан тоогоор 25 удаа хийж 124 зөрчил илрүүлж 55 % ыг нь газар дээр нь засуулж 18 мэдэгдэл шаардлага хүргүүллээ. Мөн хийгдсэн хяналт шалгалтын бүртгэл хөтлөж мэдээллийн сан бүрдүүлж байна.

Дотоод хяналтын журам болон бусад хууль, тогтоомж сурталчлах зорилгоор 3 удаа 98 хүнийг хамруулан яриа таниулга хийж ханын самбараар 15 удаа сурталчилсан.

Баяр ёслол, амралтын өдрүүдэд компанийн үйл ажиллагаа явуулж буй орчинд Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх эргүүл шалгалтыг тогтмол зохион байгуулж анхааруулга сэрэмжлүүлэг өгч ажилласан.

2016 оны 4-р сард Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Дарханы мэргэжлийн хяналтын хэлтэс хамтарсан шалгалттай тул түүнийг угтаж өнгөрсөн онд хийгдсэн шалгалтын мөрөөр заагдсан дутагдлыг арилгах, засах ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна.

8. Нүүрс угаах үйлдвэрийн үйл ажиллагааны талаар

Нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн хувьд 2014 оноос угсралтын ажил нь эхэлсэн угаах үйлдвэрийн бүтээн босголтын ажлыг 2015 оны 4-р сард хийж дуусган туршилтын ажлыг эхлүүлэн 6-р сарын 17-нд үйлдвэрийн нээлтээ хийсэн нь гол үйл явдал байлаа.




Үүний зэрэгцээ баяжуулсан нүүрсийг гадаад зах зээлд борлуулах талаар БНСУ-ын “Саммок шиппинг” ХХК-тай хамтран ажиллах санамж бичигт 2015 оны 6 сарын 19-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан нь чухал үйл явдал болсон юм.




Нүүрс баяжуулах үйлдвэрт туршилт жигдрүүлэлтийн хүрээнд 2015 онд хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн үзүүлэлтийг хүснэгтэд үзүүлэв.

Нүүрсний төрөл	Үндсэн блоккийн нүүрс	Хойд блоккийн нүүрс	Хуучин нөөцийн нүүрс	Нийт хэмжээ
Нийт тэжээсэн нүүрс /тонн /	12359	1959	942	15259
Баяжуулсан нүүрс /тонн /	4437	256	176	4869
Нунтаг нүүрс /тонн /	4776	886	612	6274
Баяжуулсан нүүрсний гарц	36%	13%	19%	
Тэжээсэн нүүрсний илчлэг /ккал/	4550	3507	4320	4126
Баяжуулсан нүүрсний илчлэг /ккал/	4961	4965	4923	4950
Нунтаг нүүрсний илчлэг /ккал/	4243	3682	3725	4050



Угаах төхөөрөмж



Угаагдаад гарч байгаа нүүрс

9. Дүгнэлт, 2016 оны зорилт

2015 оны уулын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж үзвэл гадаад нөхцөл байдлаас хамааралтай санхүүгийн хүндрэл техникийн засвар үйлчилгээнд нөлөөлсөн, техникийн ашиглалтыг сайжруулах ажил зохих төвшинд хүрээгүй зэрэг шалтгаанаар хөрс хуулалтын төлөвлөгөөт үзүүлэлт тасарсан хэдий ч уулын ажлын дотоод зохицуулалтыг сайн хийж нүүрс олборлолтын хэмжээг өмнөх оноос нэмэгдүүлэн ХАБЭА-н үйл ажиллагааг идэвхжүүлсэн жил байлаа.

2016 онд уулын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд дараахь зорилт дэвшүүлэн ажиллаж байна:

- Уулын үйлдвэрлэлийн төлөвлөгөөт үзүүлэлтийг ханган биелүүлэх, өмнөх оноос ахиулах
- Техникийн ашиглалтын хувийг өмнөх оноос нэмэгдүүлэх
- 2017 оны эхэнд авахад бэлэн 150-200 мян.тн нүүрсний нөөцтэй шилжих
- Ашиглалтын хайгуулын ажлыг эрчимжүүлэн нөөц нэмэгдүүлэх
- ХАБЭА-н үйл ажиллагааг идэвхжүүлэн хүрсэн төвшинг ахиулах
- Байгаль орчин хамгаалалт, нөхөн сэргээлтийн ажлыг зохих төвшинд хийх
- Үйлдвэрлэлийн бүхий л үйл ажиллагаанд дотоод хяналтыг сайжруулах
- Олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх ойрын ба хэтийн уулын ажлын төлөвлөлтийг бүрэн хийж цаашдын өрнөлтийн бэлтгэл хангах